

<b>Баримт бичгийн нэр:</b>		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ГЭРЧИЛГЭЭ ЦУЦЛАХ ЖУРАМ	
<b>Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:</b>		СХЗГ-08-ББ-01(02):2014	
<b>Баталсан огноо:</b>	2023.08.11	<b>Баримт бичгийн хувилбар:</b>	II

## 1. Зорилго

Энэхүү журам нь Стандартчилал, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны газраас Менежементийн тогтолцоо, бүтээгдэхүүн, үйлчилгээ, халал стандартын баталгаажуулалтыг олгох, хадгалах, хугацааг сунгах, гэрчилгээг цуцлах үйл ажиллагааг зохицуулна.

## 2. Хамрах хүрээ

Баталгаажуулалтын газраас тохирлын үнэлгээний үр дүн, дүгнэлтийг үнэлж цэгнэн, бусад мэдээлэлд үндэслэн баталгаажуулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаа хамаарна.

## 3. Ашигласан баримт бичгүүд

- Гуравдагч этгээдийн баталгаажуулалтын тогтолцоо стандартад тохирч буйг заах арга MNS ISO/IEC Guide 23:2003;
- Тохирлын тэмдгийг буруугаар ашиглах тохиолдолд баталгаажуулалтын байгууллагаас авах залруулах ажиллагааны заавар MNS ISO/IEC Guide 27:2003;
- Тохирлын үнэлгээ - Гуравдагч талын тохирлын тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC Guide 30:2004;
- Тохирлын үнэлгээ – Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт явуулдаг байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17021 :2013;
- Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага. MNS ISO IEC 17065:2013.
- GSO 2055-2 Тохирлын үнэлгээ – Халал баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлагууд
- OIC/SMIIC 2:2019 “Тохирлын үнэлгээ. Халал баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлагууд”.

## 4 . Нэр томъёо, тодорхойлолт

**“Тохирлын гэрчилгээ”** - Тодорхой стандарт буюу бусад техникийн нөхцөлд тохирч байгаа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг гэрчлэн гуравдагч этгээдийн баталгаажуулалтын тогтолцооны журмын дагуу үйлдэж буй баримт бичиг ;

**“Баталгаажуулалтын схем”** – гэж нэг ижил тогтоосон шаардлага, дүрэм болон журам хэрэглэх тухайн бүтээгдэхүүнд хамааралтай баталгаажуулалтын тогтолцоо

**“Баталгаажуулалтын хамрах хүрээ”** бүтээгдэхүүн, үйл явц буюу үйлчилгээ, хэрэглэх баталгаажуулалтын схем, бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний тохирч буйг үнэлэх хэвлэгдсэн огноо бүхий стандарт болон бусад норматив баримт бичиг;

**“Баталгаажуулалтын байгууллага”** - Баталгаажуулалтын схемийг хэрэгжүүлэгч гуравдагч талын тохирлын үнэлгээний байгууллага .

<b>Баримт бичгийн нэр:</b>		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ГЭРЧИЛГЭЭ ЦУЦЛАХ ЖУРАМ	
<b>Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:</b>		СХЗГ-08-ББ-01(02):2014	
<b>Баталсан огноо:</b>	2023.08.11	<b>Баримт бичгийн хувилбар:</b>	II

## 5. Баталгаажуулалтын гэрчилгээ олгох

- 5.1 Баталгаажуулалтын газрын дэргэдэх орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөл нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, тогтолцоонд явуулсан үнэлгээ, дүгнэлтийг хэлэлцэж гэрчилгээ, тэмдэг хэрэглэх эрх олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэрийг гаргана.
- 5.2 Тухайн бүтээгдэхүүний норматив техникийн баримт бичгийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэлийн буюу чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын хүчинтэй хугацаа/хэрэв баталгаажуулалтын схемд орсон бол/, аудитын үр дүн, дүгнэлт болон бусад мэдээлэл(олон нийтийн мэдээлэл, аудитын тайлангийн талаар үйлчлүүлэгчээс гаргасан санал) зэргийг харгалзан гэрчилгээг гурав хүртэл жилийн хугацаагаар тогтооно.
- 5.3 Баталгаажуулалтын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд гэрчилгээг бичиж олгоно.
- 5.4 Менежментийн тогтолцоо, халал гэрчилгээ олгох, сунгахтай холбогдуулан гаргасан шийдвэрийг үндэслэн СХЗГ-ын дарга тушаал гаргана.
- 5.5 СХЗГ-ын Даргын тушаалыг үндэслэн гэрчилгээ бичигдэнэ.
- 5.6 Гэрчилгээ нь бүртгэлийн дугаартай байна.
- 5.7 Баталгаажуулалтын газраас олгох гэрчилгээний загвар нь “Үнэт цаас, түүнтэй адилтгах тооцоот баримт бичгийн журам”-ын хавсралтаар баталгаажсан байна.
- 5.8 Гэрчилгээ, тэмдэглэгээг эзэмшүүлэхтэй холбогдуулан баталгаажуулагдсан үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулна.
- 5.9 Баталгаажуулалтын газар нь олгосон гэрчилгээний хадгалалт, хэрэглээнд хяналт тавина.
- 5.10 Хэрэв үйлчлүүлэгч баталгаажуулалтын гэрчилгээ түүний хавсралтыг буруугаар ашиглах, эрх зүйн байдлын талаар хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан тохиолдолд Баталгаажуулалтын газраас анхааруулах, баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг арга хэмжээг авна.

## 6. Магадлах хяналт

- 6.1 Баталгаажуулалтын газар нь гэрчилгээний хүчинтэй үйлчлэх хугацаанд баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, удирдлагын тогтолцоо нь холбогдох шаардлагуудад үргэлжлэн нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор магадлах хяналтыг гэрээний дагуу явуулна.
- 6.2 Хэрэглэгчийн санал гомдлын мөрөөр магадлах хяналтыг явуулж болно.
- 6.3 Магадлах хяналтын дүнгээр баталгаажуулалтын хүрээг өргөтгөх, багасгах, эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгож болно.

## 7. Гэрчилгээний хугацааг сунгах

- 7.1 Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацааг дуусахаас 60 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг Баталгаажуулалтын газарт гаргана.
- 7.2 Хүсэлтийг үндэслэн холбогдох журмын дагуу тохирлын үнэлгээг явуулна.

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.  
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

<b>Баримт бичгийн нэр:</b>		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ГЭРЧИЛГЭЭ ЦУЦЛАХ ЖУРАМ	
<b>Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:</b>		СХЗГ-08-ББ-01(02):2014	
<b>Баталсан огноо:</b>	2023.08.11	<b>Баримт бичгийн хувилбар:</b>	II

## 8. Гэрчилгээг түдгэлзүүлэх

8.1 Дараах тохиолдолд гэрчилгээ эзэмшүүлэгч буюу Баталгаажуулалтын газар нь гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг албан бичгээр түр хугацаагаар зогсоож, зөрчил, доголдлыг нь арилгуулах арга хэмжээг авахуулна. Үүнд:

а) Гэрчилгээ эзэмшигчийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаанд холбогдох стандартын шаардлага хангахгүй тохиолдол илэрсэн;

б) Гэрчилгээ эзэмшигч нь энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа байдал илэрсэн;

в) бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын талаар хэрэглэгч, худалдан авагчаас үндэслэл бүхий гомдол гарсан;

г) гэрчилгээ эзэмшигч нь гэрээнд заасан үйлчилгээний үнэ, зардлыг заасан хугацаанаас хойш 30 хоногийн дотор төлөөгүй;

д) гэрчилгээ эзэмшигч гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэхтэй холбогдсон дүрэм, журмуудыг зөрчсөн;

е/ магадлах хяналт явуулахаас удаа дараа татгалзах;

ж/ давтан баталгаажуулалтыг явуулахаас татгалзах.

8.2 Гэрчилгээг түдгэлзүүлэх хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна.

8.3 Гэрчилгээг түдгэлзүүлснээр, үйлчлүүлэгчийн баталгаажуулалт нь түр хугацаагаар хүчингүй байна.

## 9. Гэрчилгээг хүчингүй болгох

Дараах тохиолдолд хүчингүй болгоно. Үүнд:

а) илэрсэн зөрчил нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт ноцтой нөлөөлөхөөр байх;

б) гэрээний нөхцлийг зөрчсөн;

в) зөвшөөрлийн хугацааг түр зогсоосон үед гэрчилгээ эзэмшигч нь тодорхой арга хэмжээ аваагүй;

г) гэрчилгээ эзэмшигч аж ахуйн нэгж татан буугдсан буюу тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ажил үйлчилгээ эрхлэхээ больсон;

д) гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;

е) гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг бусдад дур мэдэн шилжүүлсэн.

## 10. Баталгаажуулалтын шийдвэр, мэдээлэл

10.1 Баталгаажуулалтын гэрчилгээг олгох, хугацааг сунгах, эрхийг түдгэлзүүлэх, цуцлах ажиллагаанд энэхүү журмын 5.1-ийг мөрдөнө.

10.2 Баталгаажуулалтын зөвлөлийн гаргасан шийдвэрийг хавсралт 1 /СХЗГ-08-ББ-01(02)-маягт1/-ийн дагуу бүртгэнэ.

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.

Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

<b>Баримт бичгийн нэр:</b>		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ГЭРЧИЛГЭЭ ЦУЦЛАХ ЖУРАМ	
<b>Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:</b>		СХЗГ-08-ББ-01(02):2014	
<b>Баталсан огноо:</b>	2023.08.11	<b>Баримт бичгийн хувилбар:</b>	II

10.3 Баталгаажуулалтын газар нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн талаар “Баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийг бүртгэх, мэдээлэх журам”-д заасны дагуу нийтэд мэдээлнэ.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.  
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

<b>Баримт бичгийн нэр:</b>		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ, ХАДГАЛАХ, ХУГАЦАА СУНГАХ, ГЭРЧИЛГЭЭ ЦУЦЛАХ ЖУРАМ	
<b>Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:</b>		СХЗГ-08-ББ-01(02):2014	
<b>Баталсан огноо:</b>	2023.08.11	<b>Баримт бичгийн хувилбар:</b>	II

1-р хавсралт

СХЗГ-08-ББ-01(02)- маягт 1

Баталгаажуулалтын гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох,

хүрээг өргөтгөж, багасгасан талаарх нэгдсэн бүртгэл

д/д	Аж ахуй нэгж, байгууллагын нэр	Анх гэрчилгээ олгосон огноо	Бүртгэлийн дугаар	Аль нь болохыг тэмдэглэх	Үндэслэл	Шийдвэр
				<input type="checkbox"/> Өргөтгөх <input type="checkbox"/> Багасгах <input type="checkbox"/> Түдгэлзүүлэх <input type="checkbox"/> Цуцлах		

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.  
 Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.